



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 572

Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл, удирдах зөвлөлийн дарга Л.Энхтайваныг чөлөөлсүгэй.
2. Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл, удирдах зөвлөлийн даргаар Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн, дэд дарга Н.Хүдэрчулууныг баталсугай.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 433 дугаар тогтоолын хавсралтад заасан Л.Энхтайвантай холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.
4. Даатгалын тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж, хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн дарга /Н.Хүдэрчулуун/-д үүрэг болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

